



**ТӨРӨӨС ЭРҮҮЛ МЭНДИЙН ТАЛААР БАРИМТЛАХ БОДЛОГЫГ
БАЯН-ӨЛГИЙ АЙМАГТ ХЭРЭГЖҮҮЛЭХ ДЭД ХӨТӨЛБӨР
2017-2021 ОН**

ӨЛГИЙ
2017 ОН

Өмнөх үг

Төрөөс эрүүл мэндийн талаар баримтлах бодлого, хууль журмын шинэчлэлийг хэрэгжүүлэх, аймгийн эрүүл мэндийн салбарт тулгамдсан асуудлуудыг системтэй, үе шаттайгаар шийдвэрлэхээр энэхүү дэд хөтөлбөрийг боловсруулж баталлаа.

Дэд хөтөлбөрийг Эрүүл мэндийн яам (ЭМЯ), аймгийн Засаг даргын тамгын газар (АЗДТГ), Дэлхийн эрүүл мэндийн байгууллага (ДЭМБ), харьяа эрүүл мэндийн байгууллагууд, төрийн болон төрийн бус, хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагууд хамтран боловсруулсан ба цаашид хамтран хэрэгжүүлэн ажиллах үндсэн баримт бичиг болж байна.

Дэд хөтөлбөрийн гол зорилго нь хүн амд үзүүлэх эрүүл мэндийн тусламж үйлчилгээг тэдний эрэлт, хэрэгцээнд тулгуурлан аливаа өвчнөөс урьдчилан сэргийлэх, нотолгоонд суурилсан оношлогоо, эмчилгээний шинэ технологийг нэвтрүүлэх, зохистой санхүүжилтийн тогтолцоог бүрдүүлэх замаар тусламж, үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулан эх, хүүхдийн эрүүл мэндийн тулгамдсан асуудлыг шийдвэрлэхэд оршино.

Дэд хөтөлбөрийг боловсруулахад Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хууль, Монгол улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал 2030, Төрөөс эрүүл мэндийн талаар баримтлах бодлого болон Эрүүл мэндийн салбарын бодлогын баримт бичгүүд, Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр, аймгийн Засаг даргын үйл ажиллагааны мөрийн хөтөлбөр, ДЭМБ-аас зөвлөж буй Орон нутгийн Эрүүл мэндийн тогтолцоог бэхжүүлэхэд “Хэнийг ч орхигдуулахгүй байх” хандлага зэрэг үндсэн чиглэлүүдийг тусгасан болно.

Төрөөс эрүүл мэндийн талаар баримтлах бодлогыг манай аймагт хэрэгжүүлэх дэд хөтөлбөрийг боловсруулахад хамтран ажиллаж санал, бодлоо илэрхийлж, зөвлөгөө өгч ажилласан ДЭМБ, ЭМЯ, АИТХ, аймгийн ЗДТГ, төрийн болон төрийн бус байгууллагууд, ЭМГ, АНЭ, ЗӨСТ, сум, тосгон, өрхийн эрүүл мэндийн төв, сум дундын эмнэлгүүд болон хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагуудад талархал илэрхийлж, ажил, хөдөлмөрийн өндөр амжилт хүсье.

А.Гылымхан
Аймгийн Засаг дарга



БАЯН-ӨЛГИЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2017 оны 06 сарын 20 өдөр

Дураан А/945

Өлгий


Төрөөс эрүүл мэндийн талаар баримтлах
Бодлогыг хэрэгжүүлэх дэд хөтөлбөрийг
батлах тухай

Монгол улсын Засгийн газрын "Төрөөс эрүүл мэндийн талаар баримтлах бодлого батлах тухай" 2017 оны 24 дүгээр тогтоол, Монгол улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 3.1 дүгээр заалт, Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хуулийн 8.4, 8.5 дугаар заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Төрөөс эрүүл мэндийн талаар баримтлах бодлогыг хэрэгжүүлэх дэд хөтөлбөрийг хавсралтаар баталсугай.

2. Дэд хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг батлан хэрэгжүүлж, биелэлтэнд хяналт тавьж ажиллахыг Эрүүл мэндийн газар /С.Айгүл/-т эрхэлсэн салбар, харьяа нутаг дэвсгэрийнхээ хэмжээнд хэрэгжилтийг зохион байгуулж ажиллахыг аймгийн Засаг даргын зөвлөлийн гишүүд, сумдын Засаг дарга нарт тус тус даалгасугай.

3. Дэд хөтөлбөрийн төлөвлөгөөний хэрэгжилтийг хангах арга хэмжээг жил бүрийн аймгийн нийгэм, эдийн засгийг хөгжүүлэх үндсэн чиглэлд, шаардагдах хөрөнгийг улсын болон орон нутгийн төсөвт тусгах, олон улсын байгууллага, гадаад, дотоодын төсөл, хөтөлбөр, хандив тусламжид хамруулах замаар санхүүжүүлж, хэрэгжилтийг хангаж ажиллахыг Засаг даргын тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтэс, Эрүүл мэндийн газрын дарга, сумдын Засаг дарга, нарт тус тус үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА  А.ГЫЛЫМХАН

АГУУЛГА

НЭГ. ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ
ХОЁР. ДЭД ХӨТӨЛБӨРИЙН ЗОРИЛГО
ГУРАВ. ДЭД ХӨТӨЛБӨРИЙН ЗАРЧИМ
ДӨРӨВ. ДЭД ХӨТӨЛБӨРИЙН ҮНДСЭН ЧИГЛЭЛ
ТАВ. ДЭД ХӨТӨЛБӨРИЙН ЗОРИЛТУУД
ЗУРГАА. ДЭД ХӨТӨЛБӨРИЙН ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ
ДОЛОО. ДЭД ХӨТӨЛБӨРИЙН САНХҮҮЖИЛТ
НАЙМ. ДЭД ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЕ ШАТ
ХАВСРАЛТ 1. ДЭД ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ
ХАВСРАЛТ 2. ДЭД ХӨТӨЛБӨРИЙН ҮР НӨЛӨӨНИЙ БОЛОН ҮР ДҮНГИЙН ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ
ХАВСРАЛТ 3. ДЭД ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХЭД ШААРДАГДАХ САНХҮҮЖИЛТИЙН
ТООЦОО

ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛБАР

АИТХ	Аймгийн иргэдийн төлөөлөгчдийн хурал
АНЭ	Аймгийн нэгдсэн эмнэлэг
БЗДХӨ	Бэлгийн замаар дамжих халдварт өвчин
ДНБ	Дотоодын нийт бүтээгдэхүүн
ДЭМБ	Дэлхийн эрүүл мэндийн байгууллага
ЗӨСТ	Зоонозын өвчин судлалын төв
ЗДТГ	Засаг даргын тамгын газар
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал
МХЗ	Мянганы хөгжлийн зорилт
МГБССН	Монголын гэр бүлийн сайн сайхны нийгэмлэг
МСС	Мэдээлэл сургалт сурталчилгаа
МУЗГ	Монгол улсын засгийн газар
НЭМ	Нийгмийн эрүүл мэнд
НҮЭМ	Нөхөн үржихүйн эрүүл мэнд
НҮБХАС	Нэгдсэн үндэсний байгууллагын Хүн амын сан
НҮБХС	Нэгдсэн үндэстний байгууллагын Хүүхдийн сан
НҮБХХ	Нэгдсэн үндэстний байгууллагын Хөгжлийн хөтөлбөр
ӨЭМТ	Өрхийн эрүүл мэндийн төв
ХБӨ	Халдварт бус өвчин
ХДХВ/ДОХ	Хүний дархлал хомсдолын вирус/дархлалын олдмол хамшинж
ХХЭМБ	Хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллага
СДЭ	Сум дундын эмнэлэг
СӨЭМТ	Сум, өрхийн эрүүл мэндийн төв
ТББ	Төрийн бус байгууллага
ТҮ	Тусламж үйлчилгээ
ЭМАШТҮ	Эрүүл мэндийн анхан шатны тусламж, үйлчилгээ
ЭМБ	Эрүүл мэндийн боловсрол
ЭМГ	Эрүүл мэндийн газар
ЭМЯ	Эрүүл мэндийн яам
ЭМТ	Эрүүл мэндийн төв
ЭМТҮ	Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ
ЭМНДХ	Эрүүл мэнд, нийгмийн даатгалын хэлтэс

НЭГ. НӨХЦӨЛ БАЙДЛЫН ДҮН ШИНЖИЛГЭЭ

Аймгийн товч танилцуулга

Аймгийн газар нутаг нь далайн түвшнээс дээш 1301-4374 метр өргөгдсөн, уулархаг, хатуу ширүүн уур амьсгалтай. Эдийн засгийн гол салбар нь мал аж ахуй бөгөөд 2.02 сая толгой малтай.

Баян-Өлгий аймаг нийслэл Улаанбаатар хотоос 1760 км алслагдсан. Монгол улсын баруун хязгаарт байрладаг учир зам харилцаа, дэд бүтэц бусад аймгуудтай харьцуулахад харьцангуй бага хөгжсөн.

Баян-Өлгий аймаг нь 101183 хүн амтай, 22.6 мянган өрхтэй. Аймгийн төв болох Өлгий суманд 35.1 мянган хүн амьдардаг. 13 сум, 90 багтай. Жилийн цэвэр өсөлт 23.4 хувь байна. Хүн амын 36.3 хувийг 15 хүртэлх насны хүүхдүүд, 4.6 хувийг 60-аас дээш насны хүмүүс эзэлж байна. Хөдөлмөрийн насны буюу 16-59 насны хүмүүс 59.1 хувийг эзэлдэг. Хүн амын 34.7 хувь буюу 35.1 мянга нь аймгийн төвд, суурин газарт 29.8 хувь буюу 30.2 мянга нь сумын төвд, 35.5 хувь буюу 35.8 мянга нь хөдөө амьдарч байна.

Аймгийн дотоодын нийт бүтээгдэхүүн 2011 онд 82207.8 сая төгрөг байсан 2015 онд 309763.9 сая төгрөг болж өссөн үзүүлэлттэй байна. Нэг хүнд ногдох ДНБ (БӨА мян.төг) 3246.7 бол улсын нэг хүнд ногдох ДНБ 7714.3 байна. ДНБ-ий 40.0% хөдөө аж ахуй, ойн аж ахуй, ан агнуурын салбар, 17.3% эрүүлийг хамгаалах, нийгмийн үйлчилгээнд, аж үйлдвэр барилгын салбар нь 17.5%, хувийн үйлчилгээний салбар 3.3% тус тус эзэлж байна.

Баян-Өлгий аймгийн хөгжлийн стратеги нь байгаль, нийгэм эдийн засгийн давуу талдаа түшиглэн сул тал, бэрхшээл тэдгээрийн хөгжилд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, хүн төвтэй хөгжлийн хандлагыг удирдлага болгож, хүн амын амьдралын хэрэгцээг хангах, оюуны болон технологийн шинэ суурьт тулгуурласан экспортын чиглэл бүхий харьцангуй бие даасан эдийн засагтай, байгаль орчны даацад зохицсон соёл, иргэншлийг хэвшүүлэн хөгжүүлэхэд оршино. Үүнд эхний ээлжинд иргэдээ ажилтай, орлоготой, эрүүл, боловсролтой болгох явдал хамгийн гол зорилт байх болно.

Аймгийн Засаг даргын 2017-2020 оны үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрт үйлчлүүлэгчид, өрх гэр бүлийн эрхийг дээдэлсэн, эрэлт хэрэгцээг хангасан, тэгш хүртээмжтэй, эрүүл мэндийн чанартай тусламжийг үзүүлснээр эрүүл, урт наслах нөхцөл бүрдүүлэх зорилготой 13 зорилтыг тусган хэрэгжүүлж байна.

Эрүүл мэнд

2015 оны байдлаар аймгийн хэмжээнд 62 эрүүл мэндийн байгууллага үйл ажиллагаа явуулж байгаа ба нэгдсэн эмнэлэг 1, сум дундын эмнэлэг 3, сумын эрүүл мэндийн төв 10, тосгоны эрүүл мэндийн төв 1, өрхийн эрүүл мэндийн төв 4, ортой багийн эмчийн салбар 5 (Зөвхөн нэг нь л тусдаа статустай), хувийн ортой эмнэлэг 5, үүдэн эмнэлэг 7, эм ханган нийлүүлэх байгууллага, эмийн сан 21 ажиллаж эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг үзүүлж байна.

Эрүүл мэндийн газар нь аймгийн Засаг даргын дэргэдэх хэрэгжүүлэгч агентлаг бөгөөд хүн амын эрүүл мэндтэй холбоотой асуудлыг хариуцан, орон нутагт үйл ажиллагаа явуулж байгаа эрүүл мэндийн төрийн болон хувийн хэвшлийн байгууллагуудыг удирдлага арга зүйгээр хангах, үйл ажиллагаанд нь хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, заавар зөвлөмж өгч ажиллаж байна.

Манай аймгийн нэг онцлог нь үйлчлэх хүрээний хүн амын улирлын байдалтай шилжилт хөдөлгөөнтэй уялдуулан Алтанцөгц, Баяннуур, Ногооннуур сумдын бүх төрийн байгууллагууд зуны 3 сард нүүж зусландаа үйл ажиллагаа явуулдаг. Улаанхус сумын Хөххөтөл, Цэнгэл сумын Хуурай говь багуудад нүүдлийн их эмчийн салбар ажиллуулдаг.

Мөн Сагсай сумын Даян баг, Улаанхус сумын Хөххөтөл баг, Баяннуур сумын Цагаан Арал баг, Ногооннуур сумын Чихтэй багуудад их эмчийн ортой салбар ажиллуулж байна. Дээрх сумуудын тухайн багийн их эмчийн ортой салбар ажиллуулж буй гол шалтгаан нь жилийн 4 улирал тухайн багийн ард иргэд олноор багийн төвд суурьшиж амьдардаг, аймаг, сумын төвөөс алслагдсан, өвлийн улиралд зам хаагдаж, холбоо тасардагт оршино.

Эрүүл мэндийн санхүүжилт

2015 онд аймгийн эрүүл мэндийн салбарын санхүүжилтийн 81.7%-ийг (10.6 тэрбум төгрөг) улсын төсөв, 18.2%-ийг (2.4 тэрбум төгрөг) эрүүл мэндийн даатгалын сангаас, 0.1%-ийг (0.01 тэрбум төгрөг)

үйлчилгээний төлбөр ба бусад үйл ажиллагаанаас орсон орлого бүрдүүлсэн бөгөөд сүүлийн 5 жилд нийт санхүүжилт 2 дахин өссөн байна.

Эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээ улсын төсвөөс 100% санхүүждэг ба үүнд сум, өрхийн эрүүл мэндийн төвүүд багтдаг. Өрхийн ЭМТ-д нэг иргэнд ногдох тарифт зардлаар тооцон санхүүжилтийг олгодог. Энэ санхүүжилтийг эрүүл мэндийн тусламж, үйлчилгээнд зарцуулахаас гадна ажилчдын цалин хөлс, урамшуулал, нийгмийн даатгалын шимтгэл, эм, тариа, эмнэлгийн хэрэгсэл, тогтмол болон урсгал зардал зэрэг эрүүл мэндийн төвийн бүхий л үйл ажиллагаанд зарцуулдаг. Иймээс стандартын дагуу хүний нөөцийг бүрдүүлэх, тусламж үйлчилгээг үр ашигтай, цогц, тасралтгүй үзүүлэхэд хүрэлцдэггүй.

Эрүүл мэндийн байгууллагын нийт төсвийн 56.4% нь цалин, нийгмийн даатгалын шимтгэлд, 15.7% нь тогтмол зардалд, 27.9% үйл ажиллагааны зардалд ногддог.

Манай аймгийн нэг онцлог бол сумуудын багийн түвшинд их эмчийн ортой салбар эмнэлэг ажиллуулж, жилийн 4 улирал тухайн багийн ард иргэдэд эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг үзүүлэн ажиллаж байна. Энэхүү багийн төвд айл өрхүүд нь төвлөрсөн олон хүн амьдардаг, сум болон аймгийн төвөөс алслагдсан бартаад замтай байдаг тул их эмчийн салбарыг зайлшгүй байгуулан ажиллуулж байгаа болно. Гэвч тусдаа төсөв батлагдаж ирдэггүй, тухайн харьяа сумын эрүүл мэндийн төсөвт багтааж үйл ажиллагаа явуулдаг учир жил бүр цалин, шатахуун, эмийн өр гарч, төсвийн хүндрэл учруулдаг.

Эрүүл мэндийн салбарын хүний нөөц

Аймгийн эрүүл мэндийн байгууллагуудын нийт 1193 эмч, эмнэлгийн мэргэжилтэн, ажилчид 101.1 мянган ард иргэдэд эрүүл мэндийн тусламж үйлчилгээг үзүүлж ажиллаж байна. Хүн амын тоогоор 21 аймгаас эхний 5 байранд ордог боловч засаг захиргааны нэгжээс шалтгаалан эрүүл мэндийн салбарт ажиллаж байгаа эмч ажилчдын тоо 10000 хүн амд ногдох их эмч 14.9 буюу аймгуудтай харьцуулахад 21 байранд буюу аймгуудын дундажаас (19.6) бага байгаа нь ачааллыг бий болгож, эмнэлгийн тусламж үйлчилгээний чанар хүртээмжид сөргөөр нөлөөлж байна. Мөн 10000 хүн амд ногдох сувилагч 29.4 байна. Нийт эрүүл мэндийн салбарын ажиллагсдын 52.1% нь анхан шатны эрүүл мэндийн байгууллагуудад ажиллаж байгаа бол 47.9% 2 дахь шатлалд ажиллаж байна.

Эмч нарын 64.4% нь төрөлжсөн мэргэжил эзэмшсэн, бүх байгууллагууд батлагдсан орон тооны хүний нөөцөөр бүрэн хангагдсан.

Нийт ажилчдын 880 буюу 73.7% нь эмэгтэй, анхан шатанд 43.2%, аймгийн нэгдсэн эмнэлэгт 31.6%, хувийн эрүүл мэндийн байгууллагад 13.5% ажиллаж эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэн ажиллаж байна.

Насны ангиллаар нийт ажиллагсадын 22,8% нь 40-49 нас, 18,4% 20-29 насныхан эзэлдэг.

Нийгмийн эрүүл мэнд

Эрүүл мэндийн мэдээлэл, сургалт, сурталчилгаа нь зорилтот бүлгийг хамарч чадахгүй, оролцогчдод зөвхөн тэнхмийн сургалтаар мэдлэг олгодог, мэдлэг сэргээх болон хандлага дадлыг өөрчлөх, эрүүл мэндийг дэмжих үйл ажиллагааг тогтмол явуулах санхүүгийн болон хүн хүчний нөөц хомсдолтой байдал нь иргэдийн эрүүл зан үйл төлөвшиж чадахгүй байхад нөлөөлж байна.

Халдварт бус өвчлөл

Хүн ам зүйн болон нийгмийн байдал, амьдралын буруу хэвшил, зан заншилтай холбоотой хүн амын өвчлөл, нас баралтын шалтгаанд халдварт бус өвчин, түүнд нөлөөлөх эрсдэлт хүчин зүйл голлох байр суурийг эзэлж байна.

Тус аймгийн хүн амын дунд:

10000 хүн амд амьсгалын тогтолцооны өвчлөл 958.4

хоол боловсруулах тогтолцооны өвчлөл 667.8,

зүрх судасны тогтолцооны өвчлөл 648.3,

шээс бэлгийн тогтолцооны өвчлөл 608.5 ногдож байна.

Хүн амын дунд давсны хэрэглээ, буруу хооллолт, таргалалт, хөдөлгөөний хомсдол, архи, тамхины хэрэглээ зэрэг эрсдэлт хүчин зүйлийн тархалт их байгаа нь зүрхний шигдээс, артерийн даралт ихдэх өвчин, хавдар, тархины цус харвалтын тохиолдол болон тэдгээрийн хүндрэлд нөлөөлж байна.

Аймгийн Засаг даргын 2015 оны А/550 тоот захирамжаар “Амьдралын буруу хэвшлээс үүдэлтэй өвчнөөс сэргийлэх, хянах” дэд хөтөлбөрийг батлуулан хэрэгжүүлж байна.

Хорт хавдар, артерийн даралт ихдэх өвчин, тархины цус харвалт, чихрийн шижин өвчний болон осол гэмтлийн тохиолдол аймгуудын дундажтай харьцуулахад харьцангуй өндөр байна.

2015 оны байдлаар хүм амын нас баралтын 66.1 хувь нь цусны эргэлтийн тогтолцооны өвчин, хорт хавдар, осол гэмтлээс шалтгаалж байна. Цусны эргэлтийн тогтолцооны эмгэгээр нас барах шалтгаанд зүрхний архаг цус хомсрох өвчин (29.2%), тархинд цус харвах (14.2%), зүрхний шигдээс (16.4%) өвчин голлох байрыг эзэлдэг. Осол гэмтлийн шалтгаант нас баралт 34 ба 23.5% амиа хорлох, 29.4% зам тээврийн ослоор, 2.9% бусад хорлогдож, 44.1% бусад ослоор нас барсан байна.

Халдварт бус өвчний эрт илрүүлгийн түвшин жилээс жилд нэмэгдэж байгаа боловч артерийн даралт ихдэх өвчин, чихрийн шижин, умайн хүзүүний хорт хавдрын эрт илрүүлгийн үзлэг 33% байгаа нь улсын дундажтай харьцуулахад (52.3%) 19.3%-иар бага байна. Эрт илрүүлгийн тусламж үйлчилгээг сайжруулахад иргэд олон нийтийн оролцоо, ажил олгогч нарын дэмжлэг чухал байна.

Халдварт өвчин

Манай аймагт бүртгэгдэж байгаа халдварт өвчний тохиолдлууд, дэгдэлтийн хүрээ, давтамжаар улсын дундажтай ойролцоо болон доогуур үзүүлэлттэй байдаг хэдий ч байгаль цаг уур, нутаг орны онцлог болон эрүүл мэндийн системийн хувьд анхаарах шаардлагатай хэд хэдэн онцлогтой.

Уулархаг бүсийн эрс тэс уур амьсгалтай холбоотой амьсгалын замын өвчлөл өндөртэй.

Сүүлийн жилүүдэд БЗДХ, тухайлбал тэмбүү, заг хүйтэн өвчлөл нэмэгдэж, төрөлхийн тэмбүүгийн тохиолдол бүртгэгдэж байна.

Сүрьеэгийн өвчлөл тогтвортой буурахгүй байна. 2015 онд үндэсний түвшинд хийгдсэн тархалтын судалгаагаар бодит түвшин бүртгэгдэж байгаа тохиолдлоос 3-4 дахин их бөгөөд тандалт судалгаа, урьдчилан сэргийлэлтийг эрчимжүүлэх чухал шаардлага байгааг нотолсон. Цаашид шатлал хооронд сорьц тэвэрлэлтийг тогтмолжуулах, чанаржуулах шаардлагатай.

Манай аймгийн хэмжээнд 2015 онд амьсгалын замын халдварт өвчин 60%, бэлгийн замын халдварт өвчин 37%, гэдэсний халдварт өвчин 2%-ыг эзэлж байна.

Суулгалт өвчний халдвар улс, аймгийн дундажаас доогуур үзүүлэлттэй байгаа амжилтыг хадгалахын тулд цаашид ундны ус, хөрс, орчны эрүүл мэнд, хог хаягдлын менежмент, стандартын шаардлага хангасан ариун цэврийн байгууламжийн тоог нэмэгдүүлэх, ариутгал, халдваргүйтгэлийн чанарын асуудлыг сайжруулах шаардлагатай.

Аймгийн хэмжээнд 2015 онд халдварт өвчний 614 тохиолдол бүртгэгдэн 10000 хүн амд 65.5 тохиолдол ногдож байна. Зарим халдварт өвчин тухайлбал 10000 хүн амд ногдох сүрьеэ өвчин 0.9 тохиолдлоор, тэмбүү 2.3 тохиолдлоор, трихомониаз 1.1 тохиолдлоор, улаан бурхан өвчин 31.4 тохиолдлоор өссөн байна.

Сүүлийн 5 жилд халдварт өвчний тохиолдол, хөдлөл зүй их байгаа нь хүн амын шилжилт хөдөлгөөн, орчны бохирдол, хүн амын эрүүл мэндийн боловсрол, зан үйл, эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанар, хүртээмж зэрэг хүчин зүйлстэй холбоотой байна.

Шинэ болон дахин сэргэж буй халдварт өвчин

Манай аймагт 2013-2015 онуудад гар хөл амны өвчин, салхинцэцэг, хачигт халдвар зэрэг шинэ болон дахин сэргэж буй халдварт өвчний тохиолдол, бактерийн гаралтай хоолны хордлого нэмэгдэх хандлагатай ба салхинцэцэг өвчлөл цэцэрлэг, сургуулийн насны дунд зонхилон тохиолдож байна.

Хүн амын дунд вируст гепатитийн өвчний шинэ тохиолдол 2011- 2013 онд 10000 хүн амд 21.5 ногдож, үүний 98%-ийг гепатит А эзэлсэн бол 2015 оноос хойш бүртгэгдээгүй.

Сүрьеэ

Сүрьеэгийн өвчлөлөөр 10000 хүн амд 4.7 буюу улсын дундажтай харьцуулахад 9.7-оор, аймгуудын дундажтай харьцуулахад 5.8-аар бага байна.

Бэлгийн замаар дамжих халдварт өвчин


2015 онд БЗДХ өвчний 227 тохиолдол бүртгэгдсэн нь өмнөх онтой харьцуулахад 7 тохиолдлоор нэмэгдсэн. Нийт бүртгэгдсэн БЗДХ өвчний 25.1% нь тэмбүү, 63% нь заг хүйтэн, 11.9% нь трихомониаз эзэлж, төрөлхийн тэмбүүгийн 3 тохиолдол бүртгэгдсэн байна.

ХДХВ/ДОХ-ын тохиолдол бүртгэгдээгүй ч өвчлөл өндөртэй Хятад, ОХУ зэрэг 2 том гүүрэнгэй байнгын ажиллагаатай хилийн боомттой, орж, гарах шилжилт хөдөлгөөн ихсэж байгаа, аялал жуулчлал, гадаадын ажиллах хүч ажиллуулдаг уул уурхай, зам, барилгын компаниудын тоо нэмэгдсэнтэй холбоотой бэлгийн замаар дамжих халдварт өвчний тохиолдол, ХДХВ/ДОХ-ын эрсдэлийг нэмэгдүүлж байна.

Дархлаажуулалт

Товлолын дагуу дархлаажуулалтанд бага насны хүүхдүүдийн 99.2% нь хамрагддаг хэдий ч хүн амын шилжилт хөдөлгөөн, хүүхдийн өвчлөлөөс шалтгаалан тун хоорондын завсардалт гарах, зарим хүүхдүүдийг дархлаажуулалтаас хоцроох явдал дархлаажуулалтын хамралтад нөлөөлж байна.

График 1 . Дархлаажуулалтын хамралтын хувь, 2012-2015



Эх үүсвэр: Аймгийн ЭМГ-ын дархлаажуулалтын мэдээ, 2010-2015

Агаарын бохирдол

Өлгий хотын агаарын чанарыг MNS4585:2016 стандарт дахь хэм хэмжээтэй харьцуулахад хүхэрлэг хийн жилийн дундаж агууламж 0.007 мг/м^3 , хүхэрлэг хийн жилийн хамгийн их агууламж 0.085 мг/м^3 , азотын давхар ислийн жилийн дундаж агууламж 0.016 мг/м^3 , азотын давхар ислийн хамгийн их агууламж 0.104 мг/м^3 байв. PM_{10} буюу том ширхэгтэй тоосны дундаж агууламж 0.349 мг/м^3 , хамгийн их агууламж нь $1,850 \text{ мг/м}^3$ -т хүрсэн байна.

Тоосны дундаж агууламж 0.349 мг/м^3 , их агууламж нь $1,850 \text{ мг/м}^3$ байв. Галлагаатай хүйтний улиралд (1-3 дугаар сард) тоосны агууламж нийт ажиглалтын 80%-д нь стандартаас давдаг нь тогтоогдсон.

Ундны усны хангамж

Аймгийн төвийн төвлөрсөн усан хангамж нийт хүн амын 14.4%-ийг хангадаг тул зөөврийн усан хангамжтай айл, өрхийн ундны усны байдалд үнэлгээ хийх шаардлагатай.

Ариун цэврийн байгууламж

Аймгийн нийт өрхийн (23322 өрх) ойролцоогоор 4 орчим хувь нь төвлөрсөн сантехникийн холболттой бие засах байгууламжтай. Бусад өрхүүдийн стандартын шаардлага хангасан ариун цэврийн байгууламжийн тоог нэмэгдүүлэх шаардлагатай.

Эх, хүүхдийн эрүүл мэнд

Аймгийн нийт хүн амын 28.6%-ийг (28864) нөхөн үржихүйн насны эмэгтэйчүүд эзэлдэг ба 2015 онд 2761 эх төрж, 2770 хүүхэд амьд төрсөн. 2011 онтой харьцуулахад төрөлт жил бүр өссөн, цаашид төрөлт ихсэх хандлагатай байна.

Эхийн эндэгдэл 100000 амьд төрөлтөнд 2011 онд 78.6, 2015 онд 72.2 болж буурсан боловч улс, аймгуудын дундажаас 46.2-оор өндөр үзүүлэлттэй байна.

Нөхөн үржихүйн насны эмэгтэйчүүдийн 40 гаруй хувь нь эрхтэн тогтолцооны эмгэгтэй. Үүнээс бөөр шээсний замын өвчин, зүрх судасны өвчин дийлэнх хувийг эзэлж байгаа нь жирэмслэлт, төрөлтийн үед хүндрэлд хүргэх гол хүчин зүйл болж байна.

Тухайн насны эмэгтэйчүүдийн 48.6% нь жирэмслэлтээс сэргийлэх ямар нэг арга хэрэглэдэг ба сүүлийн жилүүдэд жирэмслэлтээс сэргийлэх аргын хэрэглээ, хангалт буурч байна.

Хүүхдийн эрүүл мэнд

5 хүртэлх насны хүүхдийн эндэгдэл 2012 онд 1000 амьд төрөлтөд 27.9 промилль бол 2015 онд амьд төрөлтөд 31.4 промилль болж нэмэгдэж, улсын дундажаас (18.3) өндөр байна.

2015 оны байдлаар 5 хүртэлх насны хүүхдийн эндэгдлийн 40.2%-ийг нялхсын эндэгдэл, нярайн эндэгдлийн 71.1% нь нярайн эрт үеийн эндэгдэл эзэлж байна. Нярайн эндэгдлийн гол шалтгаан нь бүтэлт, амьсгал хямралын хамшинж 51.5%, перинаталь үед үүссэн зарим эмгэг, төрөлхийн хөгжлийн гажиг 23.2%-ийг тус тус эзэлж байна.

Өсвөр үеийн эрүүл мэнд

Нийт хүн амын 19.9 хувийг өсвөр үеийнхэн эзэлдэг. 10-19 насныхны дунд тэдний эрсдэлт зан үйлтэй холбоотой өвчлөл, эндэгдлийн тохиолдол, тархалт өндөр байна.

Аймгийн статистик үзүүлэлтээс харахад 2011 онд 10000 хүн амын дунд өсвөр насны хүүхдийн нас баралтын эхний байранд амьсгалын замын өвчлөл 1.9 ногдож байсан бол 2015 онд эхний байранд гэмтэл хордлого, гадна шалтгаант өвчлөл 2.4 ногдож тэргүүлж байна. Иймд өсвөр насныханд хүнсний аюулгүй байдал, зам тээврийн осол, гэмтлээс сэргийлэх, сэтгэцийн эрүүл мэндийн чиглэлээр тусгайлсан эрүүл мэндийн үйлчилгээ шаардлагатай байгааг харуулж байна.

2011 онд өсвөр насны жирэмслэлтийн эзлэх хувь 1.5, охид, хөвгүүдийн БЗДХ-ын тохиолдол 2.1 байсан бол 2015 онд өсвөр насны жирэмслэлтийн эзлэх хувь 1.4, БЗДХ-ын тохиолдол 1.2 болж буурсан.

Хүснэгт 1. 5 хүртэлх насны хүүхдийн эндэгдэл, бодит тоо, 2010-2015

Он	1 хүртэлх насны хүүхдийн эндэгдэл	Үүнээс			1-5 хүртэлх насны хүүхдийн эндэгдэл	Сумд эндсэн хүүхдийн тоо	Гэрт эндсэн хүүхдийн тоо
		0-6 хоногтой (Эрт үеийн нярай)	7-28 хоногтой	29 хоногоос 1 настай			
2010	55	15	8	32	25	63	
2011	63	35	3	25	11	48	19
2012	59	14	9	36	12	52	16
2013	48	14	9	25	18	57	21
2014	66	23	8	35	8	49	14
2015	63	35	3	25	11	33	8

Эх үүсвэр: Эрүүл мэндийн үзүүлэлт 2010-2015 ЭМХТ,

Манай аймаг улсын хэмжээнд хүн амын тоогоор 5 дугаар байранд ордог боловч эрүүл мэндийн салбарт ажиллаж байгаа хүний нөөцөөр 19 дүгээр байранд, эмчийн тоогоор 20 дугаар байранд, эмнэлгийн дунд мэргэжилтэний тоогоор 17 дугаар байранд байгаа нь нэг эмч, эмнэлгийн мэргэжилтэнд ногдох хүн

амын тоо их байгаагаас шалтгаалж ачаалал нэмэгдэж, улмаар эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанарт сөргөөр нөлөөлж байна.

Аймгийн эрүүл мэндийн салбарт ажиллаж буй 166 их эмчээс 9 эмч хүүхдийн мэргэшлийн эмч байгаа нь хүүхдийн эмчийн тоо хангалтгүй байгааг харуулж байна. Бусад мэргэжлийн эмч болон багийн бага эмч нарын хүүхдийн эрэмбэлэн ангилах, яаралтай тусламжийн болон ХӨЦМ-ийн талаарх мэдлэг, чадвар нь хангалтгүй байгаа юм. Тиймээс хүүхдийн тусламж үзүүлэн ажиллаж байгаа эмч нарыг сургаж, мэдлэг чадварыг дээшлүүлэх шаардлагатай байна.

Хүүхдийн эндэгдэл буурахгүй, улс аймгийн дунджаас өндөр байгаа нь үндсэн 3 шалтгаантай гэж үзэж байна. Үүнд:

1. Хүүхдийн мэргэжлийн эмч, сувилагчаар бүрэн хангагдаагүй.
2. Хүүхдийн яаралтай тусламж үзүүлэхэд нэн шаардлагатай тоног төхөөрөмжөөр бүрэн хангагдаагүй.
3. Эцэг, эх, асран хамгаалагч нарын эрүүл мэндийн боловсрол хангалтгүй.

ХОЁР. ДЭД ХӨТӨЛБӨРИЙН ЗОРИЛГО, ЗАРЧИМ, ЗОРИЛТ

2.1 Дэд хөтөлбөрийн зорилго

Хүн амд үзүүлэх эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг тэдний эрэлт, хэрэгцээнд тулгуурлан аливаа өвчнөөс урьдчилан сэргийлэх, нотолгоонд суурилсан оношлогоо, эмчилгээний шинэ технологийг нэвтрүүлэх, зохистой санхүүжилтийн тогтолцоог бүрдүүлэх замаар эрүүл мэндийн тогтолцоог бэхжүүлэн тусламж, үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулж, эрүүл зан үйлийг төлөвшүүлэн хүн амын дундаж наслалтыг уртасгахад оршино.

2.2 Дэд хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд баримтлах зарчим

- 2.2.1 Үйлчлүүлэгчийн эрхийг дээдэлсэн
- 2.2.2 Үйлчлүүлэгчдийн эрүүл мэндийн эрэлт хэрэгцээнд нийцсэн
- 2.2.3 Иргэдийн оролцоо, салбаруудын хамтын ажиллагаанд суурилах
- 2.2.4 Хэнийг ч орхигдуулахгүй байх

2.3 Дэд хөтөлбөрийн үндсэн чиглэл

- 2.3.1 Нийгмийн эрүүл мэнд
- 2.3.2 Эмнэлгийн тусламж, үйлчилгээ
- 2.3.3 Хүний нөөц
- 2.3.4 Эрүүл мэндийн санхүүжилт
- 2.3.5 Эрүүл мэндийн технологи
- 2.3.6 Эмзүйн тусламж, үйлчилгээ
- 2.3.7 Мэдээллийн технологи, мэдээллийн удирдлага
- 2.3.8 Эрүүл мэндийн салбарын удирдлага, зохион байгуулалт, ил тод байдал

2.4 Дэд хөтөлбөрийн зорилтууд

2.4.1 Нийгмийн эрүүл мэнд

2.4.1.1 Эрүүл мэндийн асуудлыг бусад салбарын бодлогод тусган, уялдуулж нэгдсэн зохицуулалттайгаар хэрэгжүүлэх механизмыг бүрдүүлснээр хүн амын эрүүл, аюулгүй орчинд ажиллаж, амьдрах нөхцөлийг сайжруулах.

2.4.1.2 Гэр бүл төлөвлөх, эмэгтэйчүүд эсэн мэнд амаржих, эх хүүхдийн эндэгдлээс сэргийлэх, өсвөр үеийг бэлгийн амьдралд бэлтгэх зэрэг нөхөн үржихүйн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах.

2.4.1.3 Эрүүл мэндэд сөргөөр нөлөөлөх архи, тамхины хэрэглээг хязгаарлах, хүн амыг өвчнөөс урьдчилан сэргийлэх, эрсдэлт хүчин зүйлийг бууруулах үйл ажиллагааг тогтворжуулах.

2.4.1.4 Иргэн, гэр бүл, хамт олон байгууллагын идэвхитэй оролцоонд тулгуурлан хүн амын өвчлөл, нас баралтын шалтгаан, үр дагаврыг судлах, эрт сэрэмжлүүлэх, насанд тохирсон өвчний эрт илрүүлэг, хяналтын тогтолцоог бэхжүүлэх.

2.4.1.5 Шинэ болон сэргэн тархаж байгаа халдварт өвчнийг уур амьсгалын өөрчлөлт, байгаль орчны хүчин зүйлтэй уялдуулан судлах, халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх, дархлаажуулалтын үйл ажиллагааг өргөжүүлэх.

2.4.1.6 Гэнэтийн аюул, байгалийн гамшиг, нийтийг хамарсан халдварт өвчний дэгдэлт гэх мэт эрүүл мэндийн онцгой байдлын үеийн нөөцийн бэлэн байдал, хариу арга хэмжээ шуурхай чадавхийг бүрдүүлэх.

2.4.1.7 Хүн амын эрүүл мэндэд сөргөөр нөлөөлж байгаа орчны хүчин зүйлийг бууруулах.

2.4.1.8 Нийгмийн эрүүл мэндийн чиглэлээр орон нутгийн түвшинд тогтвортой бүтэц бий болгон чадавхижуулах.

2.4.2 Эмнэлгийн тусламж, үйлчилгээ

2.4.2.1 Эмнэлгийн тусламж үйлчилгээг хүн амын нягтрал, газар зүйн байршил, бүтэц, өвчлөл, ядуурлын түвшин, шилжилт хөдөлгөөн, хүн амын эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний эрэлт, хэрэгцээтэй уялдуулан зохион байгуулах.

2.4.2.2 Өрх, сумын эрүүл мэндийн төв, нэгдсэн эмнэлэгт үзүүлэх тусламж, үйлчилгээний багцыг өргөжүүлж, хүртээмжийг нэмэгдүүлж, иргэдийн чирэгдлийг багасгах.

2.4.2.3 Орон нутгийн эрүүл мэндийн байгууллагыг өмчийн хэлбэрээс үл хамааран үйл ажиллагааны нэгдмэл байдлаар тусламж, үйлчилгээ хүргэх тогтолцоог бий болгох.

2.4.2.4 Эрүүл мэндийн байгууллага хооронд үйлчлүүлэгчийг шилжүүлэх, мэдээлэл солилцох, үйл ажиллагааны уялдаа холбоо, шуурхай байдлыг сайжруулж, эмнэлгийн тусламж, үйлчилгээний чирэгдлийг бууруулах.

2.4.2.5 Эмнэлгийн тусламж, үйлчилгээ нь “үйлчлүүлэгч төвтэй” байж тусламж үйлчилгээний төрөл, гүйцэтгэлтэй уялдсан бие даасан магадлан итгэмжлэл бүхий чанарын удирдлагын тогтолцоог хэрэгжүүлэх.

2.4.2.6 Зонхилон тохиолдох өвчний оношилгоо, эмчилгээний үр дүн тасралтгүй байдлыг хангах байнгын хяналтын тогтолцоог бүрдүүлж, сэргийлж болох өвчний хүндрэл, хөдөлмөрийн чадвар алдалт, нас баралтыг бууруулах.

2.4.2.7 Эмнэлгийн яаралтай тусламжийн төвлөрлийг сааруулж, түргэн тусламжийн дуудлагын хугацааг багасгаж, алслагдсан болон газар зүйн саад бэрхшээлтэй нутагт оршин сууж байгаа иргэдэд үзүүлэх яаралтай тусламжийн хүртээмжийг нэмэгдүүлэх.

2.4.2.8 Уламжлалт анагаах ухааны оношилгоо, эмчилгээний тусламж, үйлчилгээг өрх, сумын эрүүл мэндийн төв, нэгдсэн эмнэлэгт орчин үеийн анагаах ухаантай хослуулан хэрэгжүүлэх.

2.4.2.9 Сэргээн засах, хөнгөвчлөх, сувилахуйн тусламж, үйлчилгээний төрлийг нэмэгдүүлэн, тусламж, үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах.

2.4.2.10 Эмч мэргэжилтнийг гадаад, дотоодод сургаж, чадавхижуулах, оношилгоо, эмчилгээний шинэлэг арга, технологийг орон нутагт нэвтрүүлэх замаар иргэдийн 3 дахь шатлалын эмнэлэг рүү шилжүүлэх урсгалыг бууруулах.

2.4.3 Хүний нөөц

2.4.3.1 Орон нутгийн эрүүл мэндийн салбарын хүний нөөцийг хөгжүүлэх бодлогыг хэрэгжүүлж, хүний нөөцийн менежментийг боловсронгуй болгох.

2.4.3.2 Орон нутгийн эрүүл мэндийн салбарыг нэн шаардлагатай мэргэжлийн эмч, мэргэжилтнээр бүрэн хангаж, хөрвөх чадвартай хосолсон мэргэшлийн эмч нарыг бэлтгэх.

2.4.3.3 Хүний нөөцийн нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн аюулгүй байдалыг хангах.

2.4.4 Эрүүл мэндийн санхүүжилт

2.4.4.1 Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх, үйл ажиллагааны гүйцэтгэлд суурилсан санхүүжилтийн тогтолцоог бүрдүүлэх.

2.4.4.2 Салбарын тэргүүлэх чиглэл, хүн амын эрүүл мэндийн эрэлт хэрэгцээ, тулгамдсан асуудалд үндэслэн хөрөнгө оруулалт хийлгэх.

2.4.4.3 Эрүүл мэндийн салбарын санхүүжилтийг нэмэгдүүлэхэд орон нутгийн болон аж ахуйн нэгж, олон улсын байгууллагын оролцоог нэмэгдүүлэх.

2.4.5 Эрүүл мэндийн технологи

2.4.5.1 Хүн амын эрүүл мэндийн эрэлт хэрэгцээ, эрүүл мэндийн технологийн үнэлгээнд үндэслэсэн эрүүл мэндийн технологийн төлөвлөлтийн нэгдсэн тогтолцоог бий болгох.

2.4.5.2 Эрүүл мэндийн салбарт мөрдөж байгаа стандартуудын хэрэгжилтийг хангах.

2.4.5.3 Эрүүл мэндийн технологийн үнэлгээ, эмнэлгийн тоног төхөөрөмжийн засвар үйлчилгээ, чанарын хяналт шалгалт, тохируулга, баталгаажуулалтыг тогтмолжуулах.

2.4.5.4 Эрдэм шинжилгээ, судалгааны ажлыг дэмжих, шаардлагатай санхүүжилтийг шийдвэрлүүлэх

2.4.5.5 Эрүүл мэндийн технологийн чиглэлээр хөрөнгө оруулалт хийлгэх, дэвшилтэт технологи нэвтрүүлэх.

2.4.5.6 Орон нутагт эмчилгээ оношилгооны шинэлэг арга, технологийг нэвтрүүлэх.

2.4.6 Эмзүйн тусламж, үйлчилгээ

2.4.6.1 Төрөөс эмийн талаар баримтлах бодлогыг хэрэгжүүлэх.

2.4.6.2 Эмийн зохистой хэрэглээний талаар хэрэглэгчийн эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэх.

2.4.6.3 Эмнэлзүйн эм-зүйчийн /клиник эм зүйн/ тусламжийг эмнэлгийн тусламж, үйлчилгээний шатлалд тохируулан нэвтрүүлэх.

2.4.6.4 Эм, эмнэлгийн хэрэгсэл, эмнэлгийн тоног, төхөөрөмж худалдан авах ажиллагааны үр ашгийг сайжруулах тогтолцоог үе шаттай нэвтрүүлэх.

2.4.7 Мэдээллийн технологи, мэдээллийн удирдлага

2.4.7.1 Эрүүл мэндийн мэдээллийн тогтолцоог бэхжүүлэх.

2.4.7.2 Эрүүл мэндийн салбарын цахим тогтолцоог хөгжүүлж, эрүүл мэндийн байгууллагуудын мэдээллийн технологийг боловсронгуй болгох.

2.4.8 Эрүүл мэндийн салбарын удирдлага, зохион байгуулалт, ил тод байдал

2.4.8.1 Эрүүл мэндийн байгууллага, ажилтны эрх, үүргийн давхардлыг арилгах, зохицуулах, хянах харилцааны эрх зүйн зохицуулалтыг сайжруулах.

2.4.8.2 Эрүүл мэндийн байгууллагыг шинээр байгуулах, хүчин чадлыг нэмэгдүүлэхдээ хүн амын тоо, газар зүйн байршил, нутаг дэвсгэрийн онцлог эрүүл мэндийн эрэлт хэрэгцээний үнэлгээ, судалгаанд тулгуурлан зохион байгуулах.

2.4.8.3 Хоёр талт болон олон талт хамтын ажиллагааг салбарын бодлого, тэргүүлэх чиглэлтэй уялдуулан хөгжүүлэх, гадаадын хөрөнгө оруулалт зээл, тусламжийг тулгамдсан асуудлыг шийдвэрлэхэд шуурхай үр дүнтэй хэрэгжүүлэх.

2.4.8.4 Эрүүл мэндийн байгууллагын удирдлагын тогтолцоог сайжруулах, бүх нийтийг эрүүл мэндийн тусламж үйлчилгээнд хамруулахад төр хувийн хэвшлийн түншлэлийг өргөжүүлэх, хувийн хэвшлийн оролцоог нэмэгдүүлэх.

2.4.8.5 Эрүүл мэндийн үйлчилгээний ил тод байдлыг хангах, шийдвэр гаргахад иргэд төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж байгууллагын оролцоог нэмэгдүүлж, нийгмийн хариуцлагыг дээшлүүлэх.

ГУРАВ. ДЭД ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЕ ШАТ

Хөтөлбөрийг 2017-2026 онд 2 үе шаттай хэрэгжүүлнэ.

1 дүгээр үе шат 2017-2021

2 дугаар үе шат 2022-2026

ДӨРӨВ. ДЭД ХӨТӨЛБӨРИЙН ҮР НӨЛӨӨ, БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ

Энэхүү дэд хөтөлбөрийг хэрэгжүүлснээр “Монгол улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030”-ын 2.2.2-т заасан зорилтын I-II үе шатны зорилт болон хүрэх түвшний шалгуур үзүүлэлтийг бүрэн хангасан байна.

ТАВ. ДЭД ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХЭДШААРДАГДАХ ХӨРӨНГИЙН ХЭМЖЭЭ, САНХҮҮЖИЛТЫН ЭХ ҮҮСВЭР

5.1 Дэд хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд нийт 22143.0 сая төгрөгийн санхүүжилт шаардлагатай.

5.2 Дэд хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааг дараах эх үүсвэрээс санхүүжүүлнэ.

5.2.1 Улсын болон орон нутгийн төсөв

5.2.2 Хандивлагч орон болон олон улсын хандив, зээл, тусламж, төсөл, хөтөлбөрийн

санхүүжилт

5.2.3 Гадаад, дотоодын хөрөнгө оруулалт

5.2.4 Төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, иргэдийн тусламж, хандив

5.2.5 Бусад

ЗУРГАА. ДЭД ХӨТӨЛБӨРИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ

6.1 Дэд хөтөлбөрийн хэрэгжилтийн явцын хяналт-шинжилгээ, үнэлгээг аймгийн ЗДТГын ХШҮ-ний хэлтэс, ЭМГ 2.5 жилд нэг удаа, төгсгөлийн үнэлгээг 2021 онд хийж, тайланг аймгийн ИТХ, ЭМЯ-д танилцуулна.

6.2 Аймгийн ЗДТГ, ЭМГ дэд хөтөлбөрийн хэрэгжилтэнд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх ажлыг зохион байгуулж, шаардагдах төсвийг тооцон орон нутгийн төсөвт тусган жил бүр батлуулж байна.

ДЭД ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ
2017-2021 он

Зорилго		Хүн амд үзүүлэх эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг тэдний эрэлт, хэрэгцээнд тулгуурлан аливаа өвчнөөс урьдчилан сэргийлэх, нотолгоонд суурилсан оношлогоо, эмчилгээний шинэ технологийг нэвтрүүлэх, зохистой санхүүжилтийн тогтолцоог бүрдүүлэх замаар тусламж, үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулан дундаж наслалтыг уртасгахад оршино.					
Үр нөлөө (үр нөлөөний шалгуур үзүүлэлт)		Хүн амын дундаж наслалт – 74 Эхийн эндэгдлийн түвшин (100000 амьд төрөлтөд) – 25.0 Жирэмсэний эрт үеийн хяналтын хувь – 95.0 Тав хүртэлх насны хүүхдийн эндэгдлийн түвшин (1000 амьд төрөлтөд) – 15.0 Нялхасын эндэгдлийн түвшин (1000 амьд төрөлтөд) – 13.0 Гэрийн идэвхтэй эргэлтийн хувь – 30.0 Зүрх судасны өвчлөлөөс шалтгаалсан нас баралт (10000 хүн амд) – 17.4 Хорт хавдраас шалтгаалсан нас баралт (10000 хүн амд) – 9.0 Товлолт дархлаажуулалтын хамралтын хувь – 99.9 Вируст гепатитын өвчлөл (10000 хүн амд) – 0 Сүрьеэгийн тохиолдлын түвшин (10000 хүн амд) – 2.0					
№	Үйл ажиллагаа	Бүтээгдэхүүн	Шалгуур үзүүлэлт	Хэрэгжилтийг хариуцах байгууллага	Хамтран хэрэгжүүлэх байгууллага	Хэрэгжих хугацаа	Санхүүжилт (сая төгрөгөөр)
Үйл ажиллагааны чиглэл 1.		Нийгмийн эрүүл мэнд					
<i>1.1 Эрүүл мэндийн асуудлыг бусад салбарын бодлогод тусган, уялдуулж нэгдсэн зохицуулалттайгаар хэрэгжүүлэх механизмыг бүрдүүлснээр хүн амын эрүүл, аюулгүй орчинд ажиллаж, амьдрах нөхцөлийг сайжруулах</i>							
1	Эрүүл мэндийн асуудлаар аймгийн түвшинд эрүүл мэндийн дэд зөвлөл байгуулах	Дэд зөвлөл байгуулагдаж, үйл ажиллагаа жигдэрсэн байна.	Зөвлөл жилдээ 2-оос доошгүй удаа хуралдсан байна.	ЗДТГ-ын НБХ	ЭМГ	2017	-
2	Салбар хоорондын үйл ажиллагааг зохицуулах түншлэлийн баримт бичиг гарган хэрэгжүүлэх	Түншлэлийн баримт бичиг батлагдан гарч баримт бичгийг хэрэгжүүлэх төлөвлөгөө гарсан байна.	Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь	Засаг даргын дэргэдэх дэд зөвлөл	ЗДТГ-ын НБХ, ЭМГ	2017-2021	-

3	Эрүүл мэндийг дэмжигч байгууллага, өрх, иргэн бий болгох хөдөлгөөн өрнүүлэх, шагнаан урамшуулах	Байгууллага, өрх, иргэдийн оролцоотойгоор эрүүл мэндийн боловсрол олгох боломж бүрдэнэ.	Шалгарсан байгууллага, өрх,иргэний тоо	Аймаг, сумдын ЗДТГ	ЭМГ	2017-2021	10.0
4	Байгууллага, аж ахуйн нэгжүүд албан хаагч, ажилчдаа жилд 1-2 удаа эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулах	Эрт илрүүлэг сайжирна.	Үзлэгт хамрагдсан ажилчдын тоо	АЗДТГ, албан байгууллага, аж ахуйн нэгжүүд	ЭМГ, АНЭ	2017-2021	20.0
5	Эрүүл мэндийн салбарт хөрөнгө оруулалт хийж, тогтмол хамтран ажиллаж байгаа байгууллагуудыг дэмжин урамшуулах	Эрүүл мэндийн салбартай хамтран ажиллах байгууллагын тоо нэмэгдэнэ.	Хөрөнгө оруулалт хийж, шалгарсан байгууллагын тоо	АЗДТГ, Сумдын ЗДТГ	ЭМГ, харьяа эрүүл мэндийн байгууллагууд	2017-2021	10.0
6	Эрүүл мэндийн боловсрол олгох асуудлыг бусад байгууллагын үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусган, нэвтрүүлж, хэвшил болгон ажиллах	Эрүүл мэндийн боловсролыг бусад салбарын оролцоотойгоор олгох боломжтой болгоно.	Төлөвлөгөөтэй болон, хэвшил болгосон байгууллагын тоо, явуулсан үйл ажиллагааны тоо	АЗДТГ, Сумдын ЗДТГ	ЭМГ, харьяа эрүүл мэндийн байгууллагууд	2017-2021	25.0
7	Сургуулийн өмнөх насны хүүхэд болон ЕБС-ийн сурагчдад эрүүл мэндийн боловсрол олгож, хэвшил болгох	Эрүүл мэндийн боловсрол дээшилнэ.	Эрүүл мэндийн боловсрол олгох хичээлийн агуулга	БСУГ, Ерөнхий боловсролын бүх сургуулиуд, Бүх цэцэрлэгүүд	ЭМГ	2018-2019	5.0
8	Шашны байгууллагуудын төлөөллүүдийн оролцоотойгоор эрүүл зан үйл төлөвшүүлэх, эрүүл мэндийн боловсрол олгох ажлыг хэрэгжүүлэх	Иргэдийн эрүүл мэндийн боловсрол дээшилнэ.	Үйл ажиллагаа зохион байгуулсан шашны байгууллагын тоо	ЭМГ, Шашны байгууллагууд	Сум, өрхийн эрүүл мэндийн төвүүд	2017-2021	15.0
<p><i>1.2 Гэр бүл төлөвлөх, эмэгтэйчүүд эсэн мэнд амаржих, эх хүүхдийн эндэгдлээс сэргийлэх, өсвөр үеийг бэлгийн амьдралд бэлтгэх зэрэг нөхөн үржихүйн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах</i></p>							

1	16-49 насны эмэгтэйчүүдийн дунд зонхилон тохиолдох өвчлөлийг эрт илрүүлэг үзлэг зохион байгуулж, гэр бүл төлөвлөлтөнд хамруулах	Өвчлөлийг эрт илрүүлэх боломж бүрдэнэ.	Үзлэгт хамрагдсан эмэгтэйчүүдийн тоо, эрүүлжүүлэлтийн хувь, гэр бүл төлөвлөлтөнд хамрагдсан эмэгтэйчүүдийн хувь	ЭМГ, АНЭ	Сум, тосгон, өрхийн ЭМТ	2017-2019	10.0
2	“Эх хүүхдэд ээлтэй” эмнэлэг, байгууллага болох хөдөлгөөнийг өрнүүлэх, орчин бүрдүүлэх, эх хүүхдийн сэргийлж болох эндэгдлийг бууруулахад бусад салбарын чиг үүргийг тодорхойлж хамтран ажиллах	Эх хүүхдийн эндэглийн бууруулахад бусад салбарын оролцоог хангана.	Хөдөлгөөн өрнүүлсэн байгууллагын тоо	Албан байгууллагууд	Харьяа эрүүл мэндийн байгууллагууд	2017-2021	50.0
3	Олон эмэгтэй ажилтантай байгууллага, аж ахуйн нэгжид хүүхэд саатуулах, хүүхэд хөхүүлэх өрөө гаргах зэргээр эх хүүхдэд ээлтэй орчин бүрдүүлэх	Хүүхэд хөхөөр хооллох боломж бүрдэнэ, хүүхдийн өвчлөл буурч, өсөлт хөгжилт хэвийн явагдана.	Хүүхдэд ээлтэй орчин бүрдүүлсэн байгууллагын тоо	Албан байгууллагууд	Харьяа эрүүл мэндийн байгууллагууд	2017-2021	20.0
4	Эрэгтэйчүүд олноор ажиллаж, суралцдаг салбарын ажилтан, албан хаагч, цэргүүдэд нөхөн үржихүйн эрүүл мэндийн мэдээлэл сургалт, сургалчилгааг тогтмол хийж, хамтран ажиллах	Эрэгтэйчүүдийн эрүүл мэндийн боловсрол дээшилнэ.	Мэдээлэл сургалт, сургалчилгаа явуулсан байгууллагын тоо, хамрагдсан хүний тоо	Албан байгууллагууд	Харьяа эрүүл мэндийн байгууллагууд, НТБТ, ГБХЗХГ, ЗХТ	2017-2021	20.0
5	ХИС-ийн Баян-Өлгий дахь салбар сургууль, МСҮТ-ийн сургалтын хөтөлбөрт нөхөн	Нөхөн үржихүйн эрүүл мэндийн мэдээлэл авснаар тусламж үйлчилгээ хамрагдах зан үйл төлөвшинэ.	Тусган хэрэгжүүлсэн байдал	ХИСийн Баян-Өлгий дахь салбар сургууль,	ЭМГ, БСУГ, харьяа эрүүл мэндийн байгууллагууд	2017-2021	10.0

	үржихүйн эрүүл мэндийн боловсрол олгох асуудлыг тусган хэрэгжүүлэх			МСҮТ			
6	Сургууль завсардсан өсвөр насны хүүхэд, ажилгүй залуучуудад нөхөн үржихүйн эрүүл мэндийн боловсрол олгох	Сургууль завсардсан өсвөр насны хүүхдүүд болон ажилгүй залуучуудын эрүүл мэндийн боловсрол дээшилнэ.	Хамрагдсан хүний тоо, Үйл ажиллагааны тоо	БСУГ, ГБХЗХГ, НТБТ, ЗХТ	Харьяа эрүүл мэндийн байгууллагууд,	2017-2021	25.0
<p><i>1.3 Эрүүл мэндэд сөргөөр нөлөөлөх архи, тамхины хэрэглээг хязгаарлах, хүн амыг өвчнөөс урьдчилан сэргийлэх, эрсдэлт хүчин зүйлийг бууруулах үйл ажиллагааг тогтворжуулах</i></p>							
1	Амьдралын буруу хэвшлээс үүдэлтэй өвчнөөс сэргийлэх чиглэлийн сургалт сурталчилгаа явуулж, эрүүл мэндийн боловсрол олгох	Иргэд эрүүл мэндийн боловсрол дээшилнээр амьдралын зөв хэв маяг төлөвшинө	Хамрагдсан хүний тоо,	ЭМГ, АНЭ, Харьяа эрүүл мэндийн байгууллагууд,	Хэвлэл мэдээллийн байгууллагууд	2017-2021	20.0
2	Албан байгууллага, аж ахуйн нэгжүүдийн албан хаагчдыг БЖИ-ийн судалгаанд хамруулж, ажлын байран дах дасгал хөдөлгөөнийг идэвхижүүлэх	Ажлын бүтээмж дээшилнэ.	Ажлын байран дахь дасгал хийдэг байгууллага, хүний тоо	ЭМГ	Аж ахуйн нэгж байгууллагууд	2017-2021	3.0
3	2-16 насны хүүхдийн дунд зонхилон тохиолдох өвчлөлийг эрт илрүүлж, эрүүлжүүлэх ажил зохион байгуулах	Өвчлөл эндэгдэл буурна.	Зохион байгуулсан ажил, хамрагдсан хүүхдийн тоо	Харьяа бүх эрүүл мэндийн байгууллагууд	ЭМГ, АНЭ	2017-2021	50.0
<p><i>1.4 Иргэн, гэр бүл, хамт олон байгууллагын идэвхитэй оролцоонд тулгуурлан хүн амын өвчлөл, нас баралтын шалтгаан, үр дагаврыг судлах, эрт сэрэмжлүүлэх, насанд тохирсон өвчний эрт илрүүлэг, хяналтын тогтолцоог бэхжүүлэх</i></p>							

1	Халдварт бус өвчний эрт илрүүлгийн хамрагдалтыг нэмэгдүүлэх, урьдчилан сэргийлэх, эмчилгээ, оношилгооны технологи, хэрэгцээт эм, эмнэлгийн хэрэгслийн хангамжийг сайжруулах талаар үйл ажиллагаа зохион байгуулах	Халдварт бус өвчлөлийн тохиолдлын тоо буурна.	Эрт илрүүлэгт хамрагдсан хүний тоо, хувь	ЭМГ Аймаг, Сумын ЗДТГ, ДЗОУБ, УЗХ	ЭМГ, АНЭ, сум, тосгон, өрхийн ЭМТ	2017-2021	100.0
2	“Сэтгэцийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээг сайжруулах” аймгийн дэд хөтөлбөртэй болох	Сэтгэцийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээ сайжирна.	Үйл ажиллагааны тоо	ЭМГ	Аймгийн ЗДТГ, БСУГ	2017	20.0
3	Осол гэмтлээс сэргийлэх, ослын үед үзүүлэх анхны тусламж үйлчилгээг цаг алдалгүй хүргэх талаар сургалт сурталчилгаа зохион байгуулах	Осол гэмтлийн тоо багассан байна.	Сургалтын тоо, сургалтанд хамрагдсан хүний тоо	Харьяа эрүүл мэндийн байгуулагууд, АНЭ	ЭМГ, Цагдаагийн газар	2017-2018	10.0
<i>1.5 Шинэ болон сэргэн тархаж байгаа халдварт өвчнийг уур амьсгалын өөрчлөлт, байгаль орчны хүчин зүйлтэй уялдуулан судлах, халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх, дархлаажуулалтын үйл ажиллагааг өргөжүүлэх</i>							
1	Халдварт өвчний эрт сэрэмжлүүлэх, хариу арга хэмжээг сайжруулах	Халдварт өвчний тандалт, хяналт сайжирна	Тандалтын тоо	ЭМГ	АНЭ, сум, тосгон, өрхийн ЭМТ, ЗӨСТ	2017-2021	5.0
2	Товлолын болон сайн дурын дархлаажуулалтын хамралтыг нэмэгдүүлэх, мэдээлэл харилцааг зохион байгуулах	Дархлаажуулалтын хамралт сайжирна.	Дархлаажуултын хамралтын хувь	ЭМГ	АНЭ, сум, тосгон, өрхийн ЭМТ, ЗӨСТ	2017-2021	3.0

<i>1.6 Гэнэтийн аюул, байгалийн гамшиг, нийтийг хамарсан халдварт өвчний дэгдэлт гэх мэт эрүүл мэндийн онцгой байдлын үеийн нөөцийн бэлэн байдал, хариу арга хэмжээг шуурхай чадавхийг бүрдүүлэх</i>							
1	Гэнэтийн аюул байгалийн гамшиг, нийтийг хамарсан халдварт өвчний дэгдэлт зэрэг нийгмийн эрүүл мэндийн онцгой байдлын бэлэн байдлыг хангах	Гамшгийн үеийн бэлэн байдал хангагдана	Бэлэн байдал хангагдсан байгууллагын тоо	ЭМГ, АНЭ, сум, тосгон, өрхийн ЭМТ, ЗӨСТ	АЗДТГ, ОБГ, МХГ, ХХААХҮГ	2017-2021	20.0
<i>1.7 Хүн амын эрүүл мэндэд сөргөөр нөлөөлж байгаа орчны хүчин зүйлийг бууруулах</i>							
1	Хүн амын баталгаат ундны усны эх үүсвэрийн хүртээмж, аюулгүй байдлыг сайжруулах	Шаардлага хангасан ундны усаар хангагдана.	Шинээр гаргасан гүний худгийн тоо, Шаардлага хангасан ундны ус хэрэглэдэг өрхийн тоо	АймгийнЗДТГ -ын НБХХ, сумдын ЗДТГ, БОАЖГ, СУАТ ХХК, Хар нуур, Ховд голын сав газрын захиргаа, СХЗГ	МХГ, ЭМГ, ДЗОУБ БӨ ОНХХ	2017-2021	500.0
2	Стандартын шаардлага хангасан ариун цэврийн байгууламжийн хүртээмжийг нэмэгдүүлэх	Стандартын шаардлага хангасан ариун цэврийн байгууламжаар хангагдана.	Шаардлага хангасан ариун цэврийн байгууламжийн тоо	АймгийнЗДТГ -ын НБХХ, сумдын ЗДТГ, БОАЖГ,	МХГ, ЭМГ, ДЗОУБ БӨ ОНХХ	2017-2021	50.0
<i>1.8 Нийгмийн эрүүл мэндийн чиглэлээр орон нутгийн түвшинд тогтвортой бүтэц бий болгон чадавхижуулах</i>							
1	Албан байгууллагуудад нийгмийн эрүүл мэндийн асуудал хариуцсан орон тооны бус ажилтантай болгох, сургах	Нийгмийн эрүүл мэндийн боловсрол олгох ажлыг бусад салбар, байгууллагуудтай хамтран хэрэгжүүлэх боломжтой болно	НЭМ-ийн орон тооны ажилтантай болж үйл ажиллагаа явуулсан байгууллагын	ЭМЯ, Аймгийн ЗДТГ, ЭМГ	Албан байгуулла-гууд	2017-2021	-

			тоо				
2	Эрүүл мэндийн анхан шатны байгууллагад ажиллаж байгаа эмнэлгийн мэргэжилтнүүдийг НЭМ-ийн чиглэлээр чадавхижуулах	Эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдийн нийгмийн эрүүл мэндийн талаарх мэдлэг, чадвар сайжирна	Үйл ажиллагааны тоо, тайлан	ЭМГ	НТБ, ДЗОУБ БӨ ОНХХ	2017-2021	10.0
Үйл ажиллагааны чиглэл 2.		Эмнэлгийн тусламж, үйлчилгээ					
<i>2.1 Эмнэлгийн тусламж үйлчилгээг хүн амын нягтрал, газар зүйн байршил, бүтэц, өвчлөл, ядуурлын түвшин, шилжилт хөдөлгөөн, хүн амын эрүүл мэндийн тусламж үйлчилгээний эрэлт, хэрэгцээтэй уялдуулан зохион байгуулах</i>							
1	Алслагдсан багийн иргэдийг явуулын төрөлжсөн мэргэжлийн эмчийн үзлэгт хамруулах, эрүүлжүүлэх	Алслагдсан хүн амд үзүүлэх төрөлжсөн мэргэжлийн эмчийн тусламж үйлчилгээний хүртээмж нэмэгдэнэ	Нарийн мэргэжлийн үзлэгт хамрагдсан хүний тоо, эрүүлжсэн хүний тоо	АНЭ	ЭМГ, СДЭ, сумын ЭМТ	2017-2021	500.0
2	Эмнэлгийн мэргэжилтнүүдийг жилд 2 удаа урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулах эмчлэн эрүүлжүүлэх	Салбарын ажилтнууд эрүүл мэндийн үзлэгт хамрагдана	Урьдчилан сэргийлэх үзлэгт хамрагдсан эрүүл мэндийн ажилчдын тоо, эрүүлжүүлсэн хувь	АНЭ, сум, тосгон, өрхийн ЭМТ	ЭМГ,	2017-2021	200.0
3	Эх хүүхдийн хяналтыг сайжруулах “Эх, хүүхэд, НҮЭМ” үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөө боловсруулж батлуулах	Эх, хүүхдийн өвчлөл эндэгдэл буурна.	Өвчлөл, эндэгдлийн тоо Төлөвлөгөө батлагдсан байна.	АНЭ, сум, тосгон, өрхийн ЭМТ	Аймаг, сумдын ЗДТГ, ЭМГ	2017-2021	500.0
	Хүүхдийн оношилгоо,	Хүүхдийн тусламж үйлчилгээ	Шинээр	СДЭ,	ЭМЯ,	2017-2021	800.0

4	эмчилгээнд шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангах	сайжирна	хангагдсан багаж тоног төхөөрөмжийн тоо	сум, тосгон, өрхийн ЭМТ	ЭМГ, олон улсын төсөл хөтөлбөрүүд		
5	Эх, хүүхдийн чиглэлээр тасралтгүй чадавхжуулах сургалт хийх	Эмч мэргэжилтнүүд чадавхжина	Сургалтын тоо Сургалтанд хамрагдсан эмч мэргэжилтний тоо	АНЭ, сум, тосгон, өрхийн ЭМТ	ЭМЯ, ЭМГ, олон улсын төсөл хөтөлбөрүүд	2017-2021	250.0
<i>2.2 Өрх, сумын эрүүл мэндийн төв, нэгдсэн эмнэлэгт үзүүлэх тусламж үйлчилгээний багцыг өргөжүүлж, хүртээмжийг нэмэгдүүлж, иргэдийн чирэгдлийг багасгах</i>							
1	Тусламж үйлчилгээний багцын хэрэгжилтийг сайжруулах	Анхан шатны байгууллагууд ӨОУА-ын дагуу тусламж үйлчилгээ үзүүлнэ.	Багцын хэрэгжилтийн хувь	Сум дундын эмнэлэг, сум, тосгон, өрхийн ЭМТ	ЭМГ, АНЭ	2017	5.0
2	Амьсгалын замын өвчний үед үзүүлэх тусламжийн эмнэлзүйн удирдамжийг мөрдөх, эмч мэргэжилтэн сургах	АЗӨ-ны өвчлөлийн үед үзүүлэх тусламж сайжирч, эндэгдэл буурна	АЗӨ-ний тоо, үүнээс шалтгаалсан эндэгдлийн тоо	Сум дундын эмнэлэг, сум, тосгон, өрхийн ЭМТ	ЭМЯ, ЭМГ, олон улсын төсөл хөтөлбөрүүд	2017-2021	250.0
<i>2.3 Орон нутгийн эрүүл мэндийн байгууллагыг өмчийн хэлбэрээс үл хамааран үйл ажиллагааны нэгдмэл байдлаар тусламж үйлчилгээ хүргэх тогтолцоог бий болгох</i>							
1	Улсын болон хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагуудын орлон болон дэлгэн ажиллах дагнасан тусламжийн чиглэлээр эмч мэргэжилтнүүдийг сургах хамтран ажиллах	Тусламж үйлчилгээний хүлээгдэл багасаж, ачаалал тэнцвэржиж, чирэгдэл буурна	Орны эргэлтийн тоо, бэлтгэгдсэн эмнэлгийн мэргэжилтний тоо	АНЭ, хувийн эмнэлгүүд	Аймгийн ЗДТГ, ЭМГ	2017-2021	50.0
<i>2.4 Эрүүл мэндийн байгууллага хооронд үйлчлүүлэгчийг шилжүүлэх, мэдээлэл солилцох, үйл ажиллагааны уялдаа холбоо, шуурхай байдлыг сайжруулж, эмнэлгийн тусламж үйлчилгээний чирэгдлийг бууруулах</i>							
1	Эрүүл мэндийн байгууллага хооронд	Мэдээллийн шуурхай байдлыг хангана	Шатлал хооронд	Сум дундын эмнэлэг, сум,	АНЭ, Улсын	2017-2021	100.0

	үйлчлүүлэгчийг шилжүүлэх, цахим бүртгэл мэдээллийг сайжруулах		шилжсэн үйлчлүүлэгчийн тоо	тосгон, өрхийн ЭМТ	клиникийн эмнэлгүүд		
<i>2.5 Эмнэлгийн тусламж үйлчилгээ нь “үйлчлүүлэгч төвтэй” байж тусламж үйлчилгээний төрөл, гүйцэтгэлтэй уялдсан бие даасан магадлан итгэмжлэл бүхий чанарын удирдлагын тогтолцоог хэрэгжүүлэх</i>							
1	Тусламж үйлчилгээний бэлэн байдлыг хангаж, чанар, хүртээмжийг сайжруулах	Үйлчлүүлэгчийн сэтгэл ханамж дээшилнэ	Сэтгэл ханамжийн судалгааны дүн	АНЭ, сум, тосгон, өрхийн ЭМТ	ЭМГ	2017-2021	60.0
2	Чанарын удирдлага, хяналтын тогтолцоог салбарын хэмжээнд бэхжүүлэх	ЭТҮ-ний чанар сайжирна	Хийгдсэн хяналтын тоо	АНЭ, сум, тосгон, өрхийн ЭМТ	ЭМГ	2017-2021	100.0
<i>2.6 Зонхилон тохиолдох өвчний оношилгоо, эмчилгээний үр дүн тасралтгүй байдлыг хангах байнгын хяналтын тогтолцоог бүрдүүлж, сэргийлж болох өвчний хүндрэл, хөдөлмөрийн чадвар алдалт, нас баралтыг бууруулах</i>							
1	Хүн амын өвчлөлийн сүүлийн 10 жилийн суурь судалгааг аймаг, сумдаар гаргах	Зонхилон тохиолддог өвчлөлийг бууруулах хөтөлбөр боловсруулна	Судалгааны тоо, хөтөлбөрийн тайлан	Сум, тосгон, өрхийн ЭМТ	НЭМХ, Аймаг, сумдын ЗДТГ, ЭМГ	2018-2020	500.0
<i>2.7 Эмнэлгийн яаралтай тусламжийн төвлөрлийг сааруулж, түргэн тусламжийн дуудлагын хугацааг багасгаж, алслагдсан болон газар зүйн саад бэрхиээлтэй нутагт оршин сууж байгаа иргэдэд үзүүлэх яаралтай тусламжийн хүртээмжийг нэмэгдүүлэх</i>							
1	Алслагдсан хүн амд эмнэлгийн яаралтай тусламжийг бүсчилж сум дундын эмнэлгүүдийг түшиглэн үзүүлэх, тоноглогдсон машинаар хангах	ЯТ-ийн төвлөрөл саарч, дуудлагад зарцуулагдах хугацаа багасна	Сум дундын эмнэлэгт тойргийн эрүүл мэндийн төвөөс хандсан хүний тоо	АНЭ, СДЭ	ЭМГ, сум, тосгон, өрхийн ЭМТ	2018-2021	250.0
2	Хүүхдийн болон насанд хүрэгчдийн түргэн тусламжийг тусгаарлах, иргэдийн оршин суугаа	Ачаалал багасч, хүртээмж сайжирна	Дуудлагын тоо	АНЭ	ЭМЯ, Аймаг сумдын ЗДТГ, ЭМГ,	2017-2021	500.0

	хаягжилтийг шинэчлэх				олон улсын төсөл хөтөлбөрүүд		
2.8 Уламжлалт анагаах ухааны оношилгоо, эмчилгээний тусламж, үйлчилгээг өрх, сумын эрүүл мэндийн төв, нэгдсэн эмнэлэгт орчин үеийн анагаах ухаантай хослуулан хэрэгжүүлэх							
1	Уламжлалт анагаах ухааны оношилгоо эмчилгээний тасаг нэгж байгуулах, тоног төхөөрөмжөөр хангах, мэргэжилтнийг сургах	Эмийн бус эмчилгээний аргыг нэвтрүүлнэ.	Уламжлалт эмчилгээний тасаг нэгж, эмчлэгдсэн хүний тоо	АНЭ, сум, тосгон, өрхийн ЭМТ	ЭМЯ, ЭМГ	2017-2021	600.0
2.9 Сэргээн засах, хөнгөвчлөх, сувилахуйн тусламж, үйлчилгээний төрлийг нэмэгдүүлэн, тусламж, үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах							
1	Сувилагч, эмнэлгийн тусгай мэргэжилтний ур чадварыг дээшлүүлж, мэргэшүүлэх, харилцан туршлага солилцуулах	Сувилахуйн тусламж, үйлчилгээ-ний чанар сайжирна	Зохион байгуулагдсан сургалтын тоо, оролцогчийн тоо	АНЭ, Харьяа эрүүл мэндийн байгууллагууд	ЭМГ	2017 -2021	250.0
2	Улаанхус, Алтай сумын эрүүл мэндийн төвийг сувилахуйн жишиг сум болгох	Сэтгэлд нийцсэн сувилах үйлчилгээтэй болно.	Сувилахуйн загвар болсон ЭМТөвийн тоо	Сумын эрүүл мэндийн төв	ЭМГ	2017 -2021	10.0
